

## Орхоны хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны

2016 оны 04 сарын мэдээ

04 дүгээр сарын 25

### Байгалийн нөөц хамгаалал, ашиглалт



ТХГН болох Бат-Өлзий сумын Могойтын ам, Хамрын аманд ойн цэвэрлэгээний талбай тусгаарлалт хийгдсэнээр тендерт шалгарсан 4 ААН ойн цэвэрлэгээнд оролцлоо. Тус арга хэмжээнд зориулан Хамгаалалтын захиргаанаас 2 хяналтын пост гарган 14-21 хоногийн хугацаанд хяналт тавин ажиллаа. Ойн цэвэрлэгээнд нийт 823 куб метр мод бэлтгэж орон нутгийн төсөвт 6.354.000 төгрөгний орлого орууллаа. Ойн цэвэрлэгээнд оролцсон ААН-үүд 5 сард ойн нөхөн сэргээлтийн арга хэмжээг Могойтын аманд хийлгэхээр төлөвлөөд байна.



БОНХАЖСайдын 2016 оны 03 сарын 24-ны А/80 тоот тушаал гарсантай холбогдуулан ТХГН-т амьдарч байгаа айл өрхүүдэд ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор гарын авлага 800 ширхэг, календарь 800 ширхэгийг бэлтгэн хэвлэж айл өрхүүдээр тарааж, түймрээс сэргийлэх, хамтарч ажиллах гэрээ байгууллаа.



Их-Элстий ХХК-ийн аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглахаар ирүүлсэн төсөл хөтөлбөрийг хянаж үзээд дэмжсэн албан бичгийг ТХНУГазарт хүргүүллээ.



Хамгаалалтын захиргааны ажилчид байгууллагын хашаанд ургаж байгаа 7-н төрлийн 400 гаруй модонд сийрэгжүүлэлт, таналт, усалгаа арчилгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.



### Мэдээлэл, сургалт, сурталчилгаа

Хамгаалалтын захиргаа шинэ логотой боллоо.

“Орхоны хөндийн” БЦГазар нутагт 2010-2015 онд хэрэгжсэн НҮБ-ын ТХГНСБэхжүүлэх нь төслийн хаалтын семинар Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж хамгаалалтын захиргаа, орон нутгийн захиргаа, бүлэг нөхөрлөлийн төлөөллүүд оролцлоо. Зөвлөгөөний үеэр төслийн үр дүнд бий болсон чадавхийг бусад захиргаадад танилцуулан, хөрөнгө оруулалтыг орон нутагт хүлээлгэн өглөө.



Аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт 03 сарын 24-27-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж Хамгаалалтын захиргааны дарга, мэргэжилтэн оролцлоо.

Үзэсгэлэнгийн үеэр “Орхоны хөндийн” БЦГ-т үйл ажиллагаа явуулдаг жуулчины баазууд болон тур операторуудтай уулзан нэвтрэх хураамжийг ваучераар төлөх саналыг тавьж гэрээ байгуулж ажиллаа.

Орхоны хөндийн БЦГ-ын 20 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдах эрдэм шинжилгээний бага хуралд оролцох эрдэмтэн судлаачидад урилга хүргүүллээ.

БОЯБХУАӨДЗ төсөлд дэд төслийн дэлгэрэнгүй саналыг боловсруулан хүргүүлээд байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт байгаль орчны хяналтын улсын байцаагчдын 2015 оны тоон тайланг цахим хэлбэрээр хүргүүлсэн.

БОНХАЖЯ-ны гадаад хамтын ажиллагааны хэлтэст Турк улстай хамтарч ажиллах хүсэлтээ уламжиллаа.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвөөс жил бүр “Хүрээлэн буй орчин дахь бидний оролцоо” уриан дор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын байгаль, хүрээлэн орчин-экологийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой танин мэдэхүйн уралдаант тэмцээнийг зохион байгуулдаг.

БОНХАЖСайдын санаачлагаар энэ арга хэмжээг хөдөө орон нутагт Өвөрхангай аймгийн ЕБС-ын ахлах ангийн сурагчдын дунд анх удаа зохион байгуулж явуулахаар “Монгол улсын Улаан ном” сэдэвт сургалт танин мэдэхүйн тэмцээний удирдамж, тэмцээн зохион байгуулах журам бусад холбогдох гарын авлага материалиудыг сургуулиудад өгч бэлтгэл ажилд нь оруулаад байна.

БОНХАЖЯамны хэвлэлийн албаны дарга Ганхуяг, байгаль экологи хамгаалах хөгжүүлэх иргэдийн зөвлөл ТББ-ын төлөөллүүд хамгаалалтын захиргааны ажил байдалтай танилцаж сумын удирдлагуудтай уулзаж байгаль хамгаалах ногоон цэцэрлэгт хүрээлэн байгуулах талаар хийж байгаа ажилтай танилцаж хамтран ажиллахаар заавар зөвлөгөө өглөө.

Хамгаалалтын захиргаа 4 сарын 20-нд байгаль хамгаалагчдад зориулсан нэгдсэн сургалтыг зохион байгууллаа. Сургалтын үеэр дарга мэргэжилтнүүд өөрсдийн ажлын чиглэлээр анхаарах асуудал, хийх ажлын чиглэлээр байгаль хамгаалагчдад мэдээлэл өгч ТАХ-ын ёс зүй, харилцаа, биеэ авч явах, олон нийттэй харилцахад анхаарах асуудлаар мэдэгдэл хийлээ.



Сум дундын Прокурорын газрын прокурор н.Бат-Өлзий шинээр батлагдсан Зөрчлийн тухай хуулийн талаар мэдээлэл өгч БОХУБ-ын анхаарах зарим асуудлын талаар харилцан ярилцлага хийсэн. Мөн ОХБЦГ-ын 20 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд хамт олны оролцооны талаар хэлэлцэж тохиролцлоо.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: Ч.СУУРЬТОГТОХ. МЭРГЭЖИЛТЭН